

ЗАСАГ ДАРГА

БАТЛАВ

Д.ЧИНЗОРИГ

2024 оны 04 сарын 23-ны өдөр

Тайгам

Баян-Өндөр багт инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах /хайгуултай/ техникийн тодорхойлолт

1. Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Баян-Өндөр багт 2024 онд Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах /хайгуултай/ ажил хийлгэнэ.

2. Ажлын тодорхойлолт

2.1. Худгийн өрөмдлөгийн болон барилгын явцын үеийн болон дараах үеийн гэрэл зургийг авч, худгийн солбилцлыг тодорхойлсон байх.

2.2. Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS6088:2010 стандартын дагуу өрөмдлөг, шавхалт, туршилтын ажлыг явуулах, худгийн усны шахуурга, цахилгаан үүсгүүрийг сонгох, худгийн барилга барих ажлыг гүйцэтгэх.

2.3. Худаг шинээр гаргахад худгийн барилга дотор усан сан байгуулах, халаалтын зуух, мал услах онгоц, талбайг тендерт оролцогч хариуцаж гүйцэтгэнэ.

3. Монгол улсын ХХАА-н сайд, БО-ны сайд, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 15 өдрийн 101, 189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журмыг мөрдөнө. Үүнд:

3.1. Ажлын иж бүрдэлд цооног өрөмдөх, цооногийг цэвэрлэх, шавхалт, туршилтын ажил хийх, ус шахуурга, цахилгаан үүсгүүр, суурилуулах, худгийн барилга, усан сан мал услах онгоц, талбай зэргийг барьж байгуулах ажлыг багтаана. Өрөмдмөл худгийн барилга дотор 1.5м.куб-ээс дээш багтаамжтай усан сан барьж байгуулна.

3.2. Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах тухай аймгийн ажлын хэсгийн акт №1-ийн дагуу ажлын төрөл хэмжээ өртгийг тогтооно.

3.3. Инженерийн хийцтэй худаг шинээр гаргаж хүлээлгэн өгсөн тухай аймгийн ажлын хэсгийн акт №2-ыг үйлдэж сумын комисст хүлээлгэн өгч, орон нутгийн өмчид тусгуулна.

3.4. Худаг гаргахдаа өрөмдөхийн өмнө хайгуулын ажлаар устай эсэхийг тогтоосон акт үйлдэнэ.

3.5. Худгийн цооног өрөмдлөгийн ажлын талаарх мэдээллийг өрөмдлөгийн ажлын журналд тэмдэглэнэ.

3.6. Өрөмдлөгийн ажлыг дууссаны дараа шавхалтын ажлыг заавал хийж, шавхалтын ажлын журналыг дэлгэрэнгүй үйлдэнэ.

3.7. Ашиглалтын цооногийн техникийн паспортыг хөтөлж сумын ЗДТГ-т хүлээлгэж өгнө.

3.8. Инженерийн хийцтэй худгийг шинээр гаргасан далд ажлын тухай аймгийн ажлын хэсгийн акт №3-ыг үйлдэж эзэмшигчид хүлээлгэн өгнө.

3.9. Инженерийн хийцтэй худгийн усны шахуурга, шахуургын цахилгаан үүсгүүр, цахилгааны утас, хянах самбар, холбогч хэрэгсэл, дагалдах зүйлсийг иж бүрнээр худгийн цооногт суурилуулна. Худгийн усны шахуурга нь ISO-9001 чанарын стандарт, гарал үүслийн гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, барааны болон улсын гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, барааны болон улсын гэрчилгээтэй байна.

4. Усны химийн болон бактериологийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр төлөвлөсөн байна.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ШААРДЛАГА

№	Үзүүлэлт	Тендэрт оролцогчдын санал
1. Цооногийг өрөмдөх, цооногийг тоноглох		
1.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох	
1.2	Цооногийн ашиглалтын ундарга: 2м^3 - 3м^3 ус өгөх хүчин чадалтай байна. /0,6л-ээс-1,8л доошгүй байна/	
1.3	Суултын яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.	
1.4	Шүүрийн яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.	
1.5	Ус өргөх яндангийн диаметр 25мм-ээс багагүй, материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой ISO /хүйтний улиралд тэсвэртэй/	
1.6	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцрын хольцгүй, мөхлөгийн хэмжээ нь 10-15мм-ээс томгүй байна.	
1.7	Тунгаагуурын гүн нь 2м-ээс багагүй.	
1.8	Усны чанарын сорил авах, шинжилгээ хийлгэх	

1.9	Худгийг мэргч орохооргүй тагаар тоноглох	
2. Худгийн байшин, усан сан, мал услах онгоц, талбай барих		
2.1	<p>2.1 Худгийн байшингийн - Хэмжээ /доод талдаа/: 3 х 3м, ханийн өндөр шалнаас дээш 2м.</p> <ul style="list-style-type: none"> - Контейнер байна - Ханын зузаан 38см - Ханыг дотор талаас нь шавардаж өнгийн будгаар будна. - Цооногийн дээд харалдаа 30х30см хэмжээтэй нээлхийг тохируулна хийнэ. Нээлхийг худгийг завсарлахад хэрэглэнэ. - Худгийн цонх 40х50см хэмжээтэй, хамгаалалтын төмөр сараалжин хаалттай байна. Цонхны байрлал нь мал услах онгоцны чанх харалдаа байрлана. 	
2.2	Мал услах онгоцонд ус өгөх хоолой нь 60мм диаметртэй, гаднах хананаас 2м урттай гадагшилсан ган хоолойг цонхны доор гаргах.	
2.3	Ундны ус авах хоолой нь: 60мм диаметртэй ган хоолойг цонхны доор гаргах. /ундны ус авах тохиромжтой байдлаар уртыг сонгох/	
2.4	2.4 40мм-ийн диаметртэй цоорхойг генераторын утааг гадагшлуулах зорилгоор генераторын янданд тохируулан тохиромжтой байрлалд гаргана.	
2.5	Босоо суурьтай, тоноглосон, гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан 1.5м ³ –ээс багагүй багтаамжтай ган усан сан, дээгүүрээ модон тагтай.	
2.6	<p>Мал услах онгоцны:</p> <ul style="list-style-type: none"> - Хэмжээ 9м-ээс багагүй урттай, 400мм-ийн голчтой хагас цилиндр - Материал: ган яндан хоолой буюу цутгамал төмөр бетон - Худгийн байшингаас 1-2 хэмийн налуутайгаар 2м-ийн зайд байрлуулна - Онгоцны адагт үлдэгдэл ус юүлэх жижиг нээлхийг гаргана. Нээлхийг онгоцонд ус өгөх үед эргэдэж хаадаг байхаар хийнэ. - Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолын усыг бүрэн шавхаж гаргахаар байрлуулж гаргана. - Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг аюулгүй болгож засна. 	

2.7	<p>Мал услах талбай нь: - Хэмжээ: нийт уртын дагуу 2 талдаа 2м-ийн өргөнтэй зузаан нь 10см</p> <p>- Материал: 425 маркаас доошгүй цемент хэрэглэнэ. Талбайг хийхдээ бетоныг төмөр тороор хүчитгэж өгнө. Бетон 150 маркаас дээш байна.</p> <p>- Услах талбай нь худгийн байшин болон мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуу байдалтай хийгдэх бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юүлэгдэхэд тохиромжтой байна.</p>	
3. Худгийн насос, бага оврын генератор, цахилгааны утас хянах самбар		
3.1	Гүний насос: ISO-9001 стандартын шаардлага хангасан, 7,5квт-ын хүчин чадалтай монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглахад боломжтой байх.	
3.2	Цахилгаан утас: 3 салаа, худаг ашиглах шаардлагыг хангасан, насосоос хянах самбар хүртэл үргэлжилсэн, залгаасгүй, ус өргөх янданд 2м тутамд хавчиж тогтооно. /туузаар ороож болохгүй/	
3.3	Хянах самбар: асаах унтраах товчлууртай, насос ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан/ гэрлээр асаах индикатортай, насос ажиллуулах асаагууртай байна.	
3.4	Генератор: 330В-ын бензинээр ажилладаг, /ISO стандартын шаардлага хангасан/ Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх.	
4. Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгнө.		
4.1	Талбайг цэвэрлэх	
4.2	Худаг, гүний насос, жижиг оврын генераторыг ажиллуулах,	

ХЯНАСАН:

САНХҮҮ АЛБАНЫ ДАРГА

Б.ҮҮРЦАЙХ

БОЛОВСРУУЛСАН:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ОНХС ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ЭНХЖИЛ